



Үндэсний виз мэдүүлэх заавар

Мэргэжлийг хэсэгчлэн хүлээн зөвшөөрсөн тохиолдолд ажил эрхлэх виз (§ 16d AufenthG)

Үндсэн заавар

- Гэрчилгээ, Диплом болон бусад баримт бичгийн эх хувийг өгөх ёстой. Таны визийн мэдүүлгийг шийдвэрлэсний дараа эх хувийг буцаан олгоно.
- Таны визийн мэдүүлгийг шийдвэрлэхийн тулд Герман дахь Холбооны Хөдөлмөрийн Товчоо болон Гадаадын Харьгаат Иргэдийн газрын зөвшөөрөл авдаг. Тус газраас зөвшөөрөл ирсний дараа виз олгох боломжтой.
- Визийн мэдүүлгийг дунджаар ажлын 5 хоногт шийдвэрлэнэ. Зарим тохиолдолд илүү хугацаа орж болно.
- Визийн мэдүүлгийг өгөхдөө нислэгийн тийзийн захиалга өгөх шаардлагагүй. Визтэй паспортаа авсны дараагаар тийзээ захиална уу.
- ЭСЯ-наас нэмэлт бичиг баримт шаардаж болно.
- Бүрэн гүйцэд бус визийн мэдүүлэг өгөх нь шийдвэрлэх хугацааг уртасгах бөгөөд цаашлаад татгалзах эрсдэлтэй.
- Визийн мэдүүлгийг шийдвэрлэх ажлын 5 хоног дотор угсаар болон И-Мэйлээр лавлан асуух шаардлагагүй. Энэ нь визийн хэлтсийн ачааллыг нэмэгдүүлэх тул виз мэдүүлэгч бүрт тухайлан хариулах боломжгүй.
- Визийн мэдүүлгийг шийдвэрлэхэд олон хүчин зүйлс, нөхцөл байдлыг харгалзан шалгах учраас зааврын дагуу бичиг баримтаа бүрэн бүрдүүлж өгөх нь виз гарах баталгаа биш.
- Маягтыг визийн хэлтсээс үнэ төлбөргүй авах боломжтой. Виз мэдүүлэхэд үйлчилгээний хураамж төлөх бөгөөд тухайн хураамжийг виз татгалзсан, мэдүүлгээ буцаан авсан аль ч тохиолдолд эргүүлэн олгохгүй.
- Виз мэдүүлэх бичиг баримт бүрдүүлэхдээ ямар нэгэн байгууллага эсвэл гуравдагч этгээдийн туслалцаа, үйлчилгээг ашиглах шаардлагагүй. Өгсөн мэдүүлгийн хариуцлага, үр дагаврыг зөвхөн виз мэдүүлэгч өөрөө хариуцна.
- Виз мэдүүлэгч нь ЭСЯ-ны Консулын хэлтэст биечлэн ирж бичиг баримтаа өгнө.

Ерөнхий мэдээлэл

Таны диплом, мэргэжлийн үнэмлэхийг германы холбогдох газраас хэсэгчлэн хүлээн зөвшөөрсөн (Teilanerkennungsbescheid) тохиолдолд шаардлагатай мэргэжлийн боловсролыг Германд нэхэн суралцахын хажуугаар уг салбартаа ажил эрхлэх виз мэдүүлж болно. Мэргэжлийн боловсролыг нэхэн суралцаж амжилттай төгсөж улмаар Таны мэргэжлийг Германд бүрэн хүлээн зөвшөөрсний дараа удаан хугацааны оршин суух виз мэдүүлж болно.

Гадаадад эзэмшсэн зарим нэг дээд боловсролыг Германд ердөө мэргэжлийн боловсрол гэж тооцож болно гэдгийг анхаарна уу.

Германд ажиллаж амьдрах тухай дэлгэрэнгүй мэдээллийг: www.make-it-in-germany.com



Визийн мэдүүлэгт бүрдүүлэх бичиг баримтын жагсаалт

Бичиг баримтуудыг эх хувиас гадна 1 хувь хуулбарын хамт өгнө. Визийн мэдүүлгийг шийдвэрлэсний дараа бичиг баримтын эх хувийг буцаан олгоно.

Англиас бусад хэл дээрх бичиг баримтыг герман орчуулгын хамт өгнө.

Бичиг баримтаа доорх дарааллаар эрэмбэлнэ үү.

1	Бүрэн гүйцэд бөглөсөн, виз мэдүүлэгч гарын үсгээ зурсан үндэсний визийн маягт ("VIDEX" маягт) 1 хувь	<input type="checkbox"/>
2	Биометрийн шаардлага хангасан 35*45 мм хэмжээтэй 2 хувь цээж зурагны нэгийг үндэсний визийн маягтын цээж зураг байрлах хэсэгт нааж хоёр дахь зургийг нь наалгүй авч ирнэ.	
3	Хүчинтэй гадаад паспорт	
4	Гадаад паспорт эзэмшигчийн хувийн мэдээлэл бүхий нүүрний хуулбар	
5	Мэргэжлээ хэрхэн хаана дээшлүүлэх сонирхолтой бөгөөд хаана үргэлжлүүлэн ажиллах гэж байгаа талаар болон очоод байрлах хаягаа оруулсан бичмэл тайлбар захидал (Motivationsschreiben).	
6	Өнөөг хүртэл эзэмшсэн мэргэжил, боловсрол ба эрхэлж байсан ажлаа алгасалгүй бүрэн оруулсан, хүснэгтчилсэн намтар.	
7	Erklärung zum Beschäftigungsverhältnis маягт болон Zusatzblatt A хавсралтыг Герман дахь ажил олгогч бөглөж гарын үсэг зураад илгээнэ (эх хувиар ирүүлэх шаардлагагүй).	
8	Гадаадын мэргэжлийг хүлээн зөвшөөрөх газраас Таны мэргэжлийн ур чадварыг хүлээн зөвшөөрөх, адилтган авч үзэх цаашлаад мэргэжлээрээ ажиллахын тулд тохирсон сургалт шаардлагатай байгаа тухай шийдвэр эх хувиараа. Дэлгэрэнгүй мэдээллийг: www.anerkennung-in-deutschland.de	
9	Зарим тохиолдолд: Холбооны хөдөлмөрийн товчооны урьдчилан олгосон зөвшөөрөл (Vorabzustimmung der Bundesagentur für Arbeit)	
10	Эрүүл мэндийн даатгалын баримт Ажил олгогчийн талаас хийсэн хууль ёсны эрүүл мэндийн даатгал нь Германд оршин суугаа хаягийн бүртгэлтэй, хөдөлмөрийн гэрээтэй байгууллагадаа ажиллаж эхэлснээс хойш хүчин төгөлдөр үйлчилнэ. Хөдөлмөрийн харилцаа эхлэхээс өмнө Германд ирэх бол хувийн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байх шаардлагатай. Богино хугацааны аяллын эрүүл мэндийн даатгал нь Германд үргэлжлүүлэн удаан хугацаагаар оршин суух тохиолдолд нөхөн олговрын нөхцлүүд үйлчлэхгүй болж болох юм. „Incoming-Versicherungen“ төрлийн даатгал ч мөн адил урт хугацаагаар оршин суух тохиолдолд нөхөн төлбөрийн нөхцлүүд хүчин төгөлдөр бус болох магадлалтай.	



Мэргэжлийн ур чадварын баримт	
11.1	<p>Мэргэжлийн диплом, гэрчилгээг хүлээн зөвшөөрөх газраас (Anerkennungsstelle) Таны диплом, мэргэжлийн үнэмлэхийг хэсэгчлэн хүлээн зөвшөөрсөн (Teilankennungsbescheid) ба Та мэргэжлээрээ ажиллахын тулд сургалтанд хамрагдах шаардлагатай бол:</p> <ul style="list-style-type: none">Таны дээд боловсролын диплом, мэргэжлийн үнэмлэхийг хэсэгчлэн хүлээн зөвшөөрсөн тухай шийдвэр. Зарим нэг диплом, мэргэжлийн хувьд „Defizitbescheid“ нэртэй байдаг.Мэргэжил дээшлүүлэх сургалтад бүртгүүлсэн баримт эсвэл мэдлэгийн зөрүүг шалгалт өгч батлах болсон тухай баримт. Энэхүү шалгалт нь Таны мэргэжлийн үнэмлэхийг хэсэгчлэн хүлээн зөвшөөрсөн шийдвэрийг үндэслэсэн байх ба шалгалтын сэдэв, үргэлжлэх хугацааг тодорхой тусгасан байна. Мэргэжил дээшлүүлэх сургалтын төлөвлөгөөнд сургалт хариуцсан хүний нэр болон мэдлэгийн зөрүүг хэрхэн арилгах талаар тодорхой тусгасан байх ёстой.Монголд төгссөн дээд боловсролын диплом, мэргэжлийн боловсролын үнэмлэх
11.2	<p>Мэргэжлийн диплом, гэрчилгээг хүлээн зөвшөөрөх газраас Таны диплом, мэргэжлийн үнэмлэхийг бүрэн хүлээн зөвшөөрсөн (Vollanerkennungsbeseheid) бол:</p> <ul style="list-style-type: none">Муж улсын Хүлээн зөвшөөрөх газраас олгосон Таны диплом / мэргэжлийн үнэмлэхийг бүрэн хүлээн зөвшөөрсөн гэрчилгээХөдөлмөрийн гэрээ болон ажлын байрны тодорхойлолт
11.3	<p>Герман хэлний A2 ба түүнээс дээш түвшний сертификат. ALTE стандартын дагуу хэлний мэдлэгийг шалгах эрх бүхий байгууллагаас олгосон сертификат. Das Deutsche Sprachdiplom (DSD) – Герман хэлний дипломыг мөн хүлээн зөвшөөрнө.</p> <p><i>Герман хэлний мэдлэгийн түвшин анхан шатнаас дээш гэдгийг виз мэдүүлэхдээ ярилцлага хийж баталж чадвал герман хэлний сертификат өгөх журмаас чөлөөлж болно. Визийн мэдүүлгээ өгсөнөөс хойш герман хэлний сертификатыг тодорхой хугацаанд нөхөн өгч болдог бөгөөд ЭСЯ-наас энэхүү хугацааг тодорхой зааж өгнө.</i></p>
11.4	<p>Мэргэжил дээшлүүлэх сургалтын хүрээнд Герман хэлний бэлтгэлд сурах шаардлагатай бол:</p> <p>Долоо хоногт багадаа 18 цагийн сургалттай эрчимжүүлсэн хэлний сургалтанд (Intensivkurs mit mindestens 18 Stunden pro Woche) бүртгүүлсэн ба төлбөрийг төлсөн баримтууд эх хувиараа.</p>
11.5	<p>Дээд боловсролын диплом, мэргэжлийн үнэмлэх хавсралтын хамт эх хувиараа</p>



Амьжиргааны баталгаа	
Германд нэг сарын амьжиргааны доод хэмжээ 1027 Евро байх бөгөөд үүнийг дараахь баримтаар баталгаажуулна:	
12.1	Германы Оршин суух тухай хуулийн 66-68-р зүйлд заасны дагуу албан ёсны батлан даалтын маягт (Verpflichtungserklärung). Энэхүү батлан даалтанд Германд оршин суух зорилгыг тодорхой заах шаардлагатай. Дэлгэрэнгүй мэдээллийг батлан даагч өөрийн хотын Гадаадын Иргэн Харьяатын газраас (Ausländerbehörde), гадаадад амьдардаг бол Герман Улсын ЭСЯ/Төлөөлөгчийн газраас авах хэрэгтэй.
12.2	Хязгаартай ашиглах данс (Sperrkonto) нээлгэх. Германы аль нэг банкинд хязгаартай ашиглах данс нээлгэж амьжиргааны баталгааг байршуулж болно. Хязгаартай данс нээхэд жуучилдаг байгууллагуудаас Та өөрөө чөлөөтэй сонгох бөгөөд дэлхий даяар жуучлалын үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын жагсаалтыг Та Холбооны Гадаад хэргийн яамны цахим хуудаснаас авч болно. Визийн мэдүүлгийг өгөхөөс өмнө хязгаартай ашиглах дансаа нээлгэж шаардлагатай мөнгөн дүнг дансандаа байршуулна уу. Визийн мэдүүлгэд зөвхөн Герман дахь банкнаас ирүүлсэн дансанд байгаа нийт Евроны хэмжээ болон сард ашиглаж болохуйц мөнгөн дүнг тодорхой заасан тодорхойлолтыг ЭСЯ хүлээн зөвшөөрдөг. Мөнгө шилжүүлсэн эсвэл гуйвуулсан баримт хангалтгүй.
Монголоос өөр орны иргэншилтэй виз мэдүүлэгч	
13	Монгол Улсад удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл
Хураамж	
14	Визийн хураамж 75 еврог монгол төгрөгөөр
Визийн мэдүүлгийн бүрэн гүйцэд байдал	
Визийн мэдүүлэгт шаардлагатай бичиг баримт бүрэн гүйцэд байгаа эсэх: <input type="checkbox"/> Гийм <input type="checkbox"/> Гүгүй, чагтлаагүй үлдсэн бичиг баримт/мэдээлэл дутуу	
Бүрэн гүйцэд бус визийн мэдүүлэг өгөх тухай мэдэгдэл	
Миний визийн мэдүүлэг бүрэн гүйцэд бус байгаа талаар надад мэдээлсэн. Визийн мэдүүлэгт шаардлагатай бичиг баримт дутуу байх нь визийг татгалзах эрсдэлтэй гэдгийг миний бие ойлгож байгаа бөгөөд визийн мэдүүлгээ өгөх хэвээр байгаа гэдгийг мэдэгдэж гарын үсгээ зурсан болно. _____ газар, огноо, гарын үсэг	